МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОВСРОЛЫН ЯАМ

ADB ASIAN DEVELOPMENT BANK

НЭГДСЭН ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖ

JICA

# БОЛОВСРОЛЫН ЯАМНЫ НЭГДСЭН ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖИЙН ТӨСЛҮҮДИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

# ТӨСЛҮҮДИЙН НЭГДСЭН МЭДЭЭЛЭЛ

| Үндсэн мэдээлэл | Төсөл 1 /АХБ/ | Төсөл 2 /АХБ/ | Төсөл 3 /ЖАЙКА/ | Төсөл 4 /АХБ/ |
|---|---|---|---|---|
| **Төслийн нэр:** | L3594-MON Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл | L4438-MON Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах нэмэлт санхүүжилтийн төсөл | Инженер технологийн дээд боловсрол төсөл | ЕБС-ийн шинжлэх ухаан, технологийн хичээлийн инновац, хамтын ажиллагааг дэмжих төсөл |
| **Хэрэгжих хугацаа:** | 2018.04.30-2026.08.31 | 2024.04.25-2027.02.28 | 2014.03.14-2026.12.31 | 2026.01.30-2029.12.31 |
| **Нийт төсөв:** | 50.0 сая ам.доллар зээл | 15.0 сая ам.доллар зээл | 7.5 тэрбум иен Зээл | 3.0 сая ам.доллар тусламж |
| **Үндсэн зорилго:** | Эдийн засгийн үед сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. | Эдийн засгийн үед сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. | Монгол Улсад өндөр мэдлэг, ур чадвар бүхий инженер, технологийн мэргэжилтэн бэлтгэж, инженерийн боловсролын өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, багшлах боловсон хүчний нөөцийг бэхжүүлж, сургалтын орчныг шинэчлэн, чанарыг сайжруулна. | ЕБС-ийн суралцагчдын оролцоо, өөртөө итгэх итгэл, хүйсийн тэгш байдлын мэдрэмж, шинжлэх ухааны үндэслэл, дижитал сургалтын үндсэн ур чадварыг сайжруулна. |

# ТӨСЛҮҮДИЙН НЭГДСЭН МЭДЭЭЛЭЛ

| Үндсэн мэдээлэл | Төсөл 1<br>Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл<br>*/АХБ/* | Төсөл 2<br>Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах нэмэлт санхүүжилтийн төсөл<br>*/АХБ/* | Төсөл 3<br>Инженер технологийн дээд боловсрол төсөл<br>*/ЖАЙКА/* | Төсөл 4<br>Ерөнхий боловсролын сургуулиудад шинжлэх ухаан, технологийн боловсрол олгох инновац, хамтын ажиллагааг дэмжих<br>*/АХБ, ЯЯБС/* |
|---|---|---|---|---|
| Төслийн бүрэлдэхүүн хэсгүүд | 1. Цэцэрлэг, сургуулийн байрны хүчин чадлыг нэмэгдүүлэх;<br>2. Сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг эцэслэх;<br>3. Шинэчилсэн сургалтын хөтөлбөрт нийлүүлэн сургалтын хэрэглэгдэхүүнийг бүрдүүлж, хангах;<br>4. Шинэчилсэн хөтөлбөр, үнэлгээний чиглэлээр багш, удирдах ажилтны мэдлэг, чадварыг дээшлүүлэх<br>5. Боловсролын үйлчилгээний төлөвлөлт, удирдлагын тогтолцоог бэхжүүлэх; | 1. Цэцэрлэг, сургуулийн байрны хүчин чадлыг нэмэгдүүлэх; | 1. Коосэн хөтөлбөр<br>2. Бакалаврын хамтарсан хөтөлбөр<br>3. Хамтарсан судалгааны хөтөлбөр<br>4. Зэргийн хөтөлбөр<br>5. Зэргийн бус хөтөлбөр<br>6. Зочин судлаач хөтөлбөр<br>7. Тоног төхөөрөмжийн худалдан авалт | 1. Багш нарын байгалийн ухаан, технологийн хичээлийг төлөвлөх, заах ур чадварыг нэмэгдүүлэх;<br>2. Байгалын ухаан, технологийн лабораторийг байгуулах;<br>3. Сургуулийн байгалийн ухаан, технологийн боловсролын инновац, хамтын ажиллагааг дэмжих орчныг сайжруулах; |

# 1

# ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙН ҮЕД БОЛОВСРОЛЫН ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН

# БҮРЭЛДЭХҮҮН 1. ЦЭЦЭРЛЭГ, СУРГУУЛИЙН ХҮЧИН ЧАДЛЫГ НЭМЭГДҮҮЛНЭ

## ХҮРСЭН ҮР ДҮН

***Сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор***

- 2 шинэ сургууль, 5 сургуулийн өргөтгөлийн барилга барьж, ашиглалтад оруулснаар сургуулийн хүчин чадлыг 3400 суудлаар нэмэгдүүлсэн.
- 2 шинэ цэцэрлэг, 12 цэцэрлэгийн өргөтгөлийн барилга барьж, ашиглалтад оруулснаар цэцэрлэгийн хүчин чадлыг 2325 ороор нэмэгдүүлсэн.
- Ашиглалтад оруулсан сургууль, цэцэрлэгт нэн шаардлагатай тавилга, тоног төхөөрөмжийг нийлүүлснээр сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлсэн.
- Ашиглалтад оруулсан 7 сургуулийн Байгалийн ухааны кабинетад шаардлагатай тоног төхөөрөмжийг нийлүүлснээр сурагчид туршилт, судалгаа хийх боломж бүрдсэн.

***3 ээлжээр хичээллэх эрсдэлийг бууруулах зорилгоор***

- Нийслэлийн 47 сургуулийн 590 ангид шаардлагатай тавилга, тоног төхөөрөмж нийлүүлж, суудлын тоог нэмэгдүүлсэн.
- Цахим-танхимын хосолсон сургалтад зориулан энгийн цахим анги 110, жишиг цахим анги 25 байгуулж, 400 гаруй багш нарыг сургаж, чадавхжуулсан.
- 2025 онд 34 сургуулийн 34 ангид цахим ангийн тоног төхөөрөмжийг нийлүүлж, хосолсон сургалтын орчныг сайжруулсан. Мөн 8 сургуульд 20 ангид 712 сурагч ширээ, 1424 сурагч сандал нийлүүлж, суудлын тоог нэмэгдүүлсэн.

***Нэмэлт ажлын хүрээнд***

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд ашиглалтад оруулсан, 2026 онд ашиглалтад оруулах сургууль, цэцэрлэгүүдэд нэн шаардлагатай тавилга, тоног төхөөрөмж нийлүүлэх **3** багц тендерийг 2025.11.29-нд зарлаж, нийлүүлэгч компаниудтай гэрээ байгуулсан.

## ҮР ДҮН

- Ерөнхий боловсролын сургуулийн **21000** орчим сурагч, цэцэрлэгийн **2325** хүүхэд төслийн үр шимийг хүртэж байна.
- **7** сургууль, **14** цэцэрлэгийг ашиглалтад оруулснаар нийт **501** (247 багш, туслах багш, 254 ажилтан) шинэ ажлын байр, орон тоо бий болсон.
- Сургууль, цэцэрлэгийн барилга нь барилгын норм, стандартыг бүрэн хангаснаас гадна тэгш хүртээмжтэй, нас хүйсийн онцлогт таарсан ариун цэврийн байгууламжтай байх шаардлагуудыг бүрэн хангасан.
- 2018 онтой харьцуулахад 2024-2025 оны хичээлийн жилд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хамрагдсан тоо **14** цэцэрлэгийн хувьд **63**, **7** сургуулийн хувьд тоо **29**-өөр нэмэгдсэн.

## Ашиглалтад орсон сургууль, цэцэрлэгүүд



СХД, 14-р хороо, 150 ортой 107-р цэцэрлэгийн өргөтгөл



СХД, 22-р хороо, 122-р сургуулийн 640 суудалтай өргөтгөл



СХД, 40-р хороо, 640 суудалтай 168 дугаар сургууль (шинэ)



Говь-Сүмбэр аймаг, Сүмбэр сум, 5 дугаар цэцэрлэгийн 120 ортой өргөтгөл



БГД, 2-р хороо, 51-р сургуулийн 420 суудалтай өргөтгөл



Баянзүрх дүүрэг, 1-р хороо, 22-р цэцэрлэгийн 150 ортой өргөтгөл

# ТӨСӨЛ 1-АХБ: ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙН ҮЕД БОЛОВСРОЛЫН ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ



## Ашиглалтад орсон сургууль, цэцэрлэгүүд



ХУД, 2-р хороо, 65-р цэцэрлэгийн 120 ортой өргөтгөл



СБД, 3-р хороо, 68-р цэцэрлэгийн 120 ортой өргөтгөл



БГД, 4-р хороо, 164-р цэцэрлэгийн 150 ортой өргөтгөл




СХД, 15-р хороо, 110-р цэцэрлэгийн 150 ортой өргөтгөл



БЗД, 16-р хороо, 8-р цэцэрлэгийн 240 ортой өргөтгөл



СБД, 10-р хороо, 17-р цэцэрлэгийн 240 ортой өргөтгөл

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
БОЛОВСРОЛЫН ЯАМ

# ТӨСӨЛ 1-АХБ: ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙН ҮЕД БОЛОВСРОЛЫН ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ

ADB
ASIAN DEVELOPMENT BANK

## Ашиглалтад орсон сургууль, цэцэрлэгүүд



Налайх дүүрэг, 3-р хороо, 240 ортой шинэ цэцэрлэг (331)



Налайх дүүрэг, 2-р хороо, "Эрдмийн оргил" ЦС сургуулийн 320 суудалтай өргөтгөл



ХУД, 3-р хороо, 18 дугаар сургуулийн 320 суудалтай өргөтгөл



Дархан-Уул аймаг, 15 дугаар баг, Дархан сум, 960 суудалтай шинэ сургууль (31 дүгээр сургууль)



СХД, 25-р хорооны 125 ортой шинэ цэцэрлэг




CW-11 СХД, 6-р хорооны 84-р цэцэрлэгийн 240 ортой өргөтгөл

# БҮРЭЛДЭХҮҮН 2: ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР БОЛОН ҮНЭЛГЭЭНИЙ ШИНЭЧЛЭЛИЙГ ЭЦЭСЛЭНЭ

## ХҮРЭХ ҮР ДҮН

- Шинэчилсэн хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн 1–12 дугаар ангийн нийт багш нарын 91 хувь буюу 30,049 багшийг чадавхжуулах сургалтад хамруулснаас 83 хувь (24,990) нь эмэгтэй багш байна.
- Суралцагчийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийг боловсруулж, БШУ-ны сайдын 2021 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн А/180 дугаар тушаалаар батлуулан, 2022–2023 оны хичээлийн жилээс хэрэгжүүлж эхэлнэ.
- Уг шалгуурыг хэрэгжүүлэх аргачлалын хамт таниулах зорилгоор ерөнхий боловсролын нийт багш нарын 61.6 хувь буюу 21,631 багшийг (үүнээс 86.7 хувь буюу 18,775 нь эмэгтэй) гурван үе шаттай сургалтад хамруулна.
- Шинээр батлагдсан суралцагчийн үнэлгээний шалгуурт нийцүүлэн 9,400 даалгаврыг шинээр боловсруулж, БҮТ-ийн даалгаврын санг баяжуулан гүйцэтгэлийн үнэлгээнд ашиглана.
- Боловсролын үнэлгээний төвд бизнесийн ухаалаг системийг хөгжүүлнэ.
- Мэргэжлийн байгууллагуудтай хамтран ЕБС-ийн менежментийг дэмжих арга зүйн зөвлөмж боловсруулна.
- ЕБС-ийн 4 хувь буюу 30 сургууль менежментийн зураглал боловсруулах, түгээн дэлгэрүүлэх чадавхтай болно.
- ЕБС-ийн 11.7 хувь буюу 119 сургуульд дээрх зөвлөмжийг түгээн дэлгэрүүлж, хэрэгжүүлнэ.
- Олон улсад магадлан итгэмжлэгдсэн багш бэлтгэх хөтөлбөрийн хэрэгжилтийн судалгаа болон 2021–2023 онд ажлын хэсгийн хийсэн судалгаанд үндэслэн багш бэлтгэх боловсролын хөтөлбөрийг шинэчилнэ.

## ХҮРСЭН ҮР ДҮН

- Боловсролын системд анх удаа суралцагчийн үнэлгээний шалгуурыг батлан хэрэгжүүлж эхэлсэн.
- Боловсрол нөхөн олгох хөтөлбөрийг шинэчлэн хэрэгжүүлсэн.
- Шууд засалтын технологийг нэвтрүүлснээр ЭЕШ-ын дүнг 3–5 минутын дотор танилцуулах боломж бүрдсэн.
- Сургуулийн өмнөх боловсрол, бага анги, байгалийн ухааны багш бэлтгэх хөтөлбөрүүдийг шинэчилсэн.
- ЕБС-ийн 26 хувь буюу зорилтот 184 сургуулиас 161 (87.5 хувь) нь СБГҮ-ний үр дүнгээр ахицтай үнэлэгдсэн.
- “Багш бэлтгэх хөтөлбөрийн үзэл баримтлал”, мөн багш, сургуулийн өмнөх боловсролын багш, бага боловсролын багшийн хөтөлбөрүүдийн сургалтын төлөвлөгөөг шинэчлэн баталсан. Эдгээр баримт бичгийг багш мэргэжлээр сургалт эрхэлдэг бусад их, дээд сургуулиуд жишиг болгон ашиглаж байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОВСРОЛЫН ЯАМ

# ТӨСӨЛ 1-АХБ: ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙН ҮЕД БОЛОВСРОЛЫН ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ

ADB ASIAN DEVELOPMENT BANK

## БҮРЭЛДЭХҮҮН 2: ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР БОЛОН ҮНЭЛГЭЭНИЙ ШИНЭЧЛЭЛИЙГ ЭЦЭСЛЭНЭ

### 01 Сургуульд суурилсан менежмент:



ССМ-ийн сургагч багшийг бэлтгэж, ЕБС-ийн удирдах ажилтныг чадавхжуулах цахим сургалт зохион байгуулах;

- 90 сургагч багш
- 184 сургуулийн 920 удирдах ажилтан

- 84 сургагч багш
- 184 сургуулийн 920 удирдах ажилтан

### 02 Сургагч багш бэлтгэх:



ССМ-ийг сайжруулах чиглэлээр орон нутгийн сургагч багшийг үе шаттайгаар чадавхжуулах;

БГ-ын 21 мэргэжилтэн ЕБС-ийн 21 захирал нийт 42 хүн

Мэргэжилтэн 21, Захирал 18, сургалтын менежер 3 нийт 42 хүн

### 03 Зөвлөн туслах:



ССМ-ийн хэрэгжилтэд арга зүйн дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах;

163 сургуулийн багш, удирдлага

163 сургуулийн 3846 багш, 475 удирдах ажилтан, 364 МХБ-ийн ахлагч

### 04 Тайлант хэлэлцүүлэг:



ССМ-ийн "Тайлант, хэлэлцүүлэг" зохион байгуулж, туршлага солилцох;
(92 видео танилцуулга, 76 ханын илтгэл, 33 танилцуулгыг түгээн дэлгэрүүлж байна)

ЕБ-ын 184 сургуулийн захирал

ЕБС-ийн 171 захирал, БГ-ын 19 мэргэжилтэн нийт 190 хүн

## БҮРЭЛДЭХҮҮН 2: ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР БОЛОН ҮНЭЛГЭЭНИЙ ШИНЭЧЛЭЛИЙГ ЭЦЭСЛЭНЭ


















Багш мэргэжийн хөтөлбөр шинэчлэлийн семинар



Шууд засалтын технологи



БАГШИЙН ИНДЕКС

| ИНДЕКС | 2022 | 2023 |
|---|---|---|
| I | 3.23% | 5.21% |
| II | 10.17% | 17.12% |
| III | 11.43% | 15.06% |
| IV | 17.11% | 14.32% |
| УРАМШУУЛАЛ АВАХ | 41.94% | 51.71% |
| V, VI УРАМШУУЛАЛ АВАХГҮЙ | 58.07% | 48.29% |

Багшийн гүйцэтгэлийн үнэлгээ-2021, 2022 он



Суралцагчийн үнэлгээний шалгуур баталсан. Судлагдахуун бүрээр




БҮТ- Бизнесийн ухаалаг систем хөгжүүлэхэд тоног төхөөрөмж нийлүүлэв

# БҮРЭЛДЭХҮҮН 3: САЙЖРУУЛСАН ХӨТӨЛБӨРТ НИЙЦҮҮЛСЭН СУРГАЛТЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮНИЙГ БҮРДҮҮЛЖ ХАНГАНА

## ХҮРЭХ ҮР ДҮН

- Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хэрэглэгдэхүүнд тавих шаардлагыг шинэчлэн боловсруулна.
- Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хэрэглэгдэхүүний жагсаалт болон түүнд тавих шаардлагыг боловсруулна. Боловсрол, шинжлэх ухааны яаманд хүлээлгэн өгсөн. Мөн ЕБ-ын хэвлэмэл сурах бичгийн стандарт (MNS 5418:2008)-ыг сайжруулна.
- ЕБС-ийн бага ангийн казах хэл дээрх сурах бичгийн орчуулгын чанарт дүн шинжилгээ хийж, орчуулгыг сайжруулна.
- Орон нутгийн СӨБ-ын сургалтын чанарыг дэмжиэх, хэрэглэгдэхүүний зөрүүг арилгах зорилгоор нийт цэцэрлэгийн 30 хувьд сургалтын хэрэглэгдэхүүн нийлүүлнэ.
- ЕБС-ийн 6-12 дугаар ангийн нийт сурагчдын 60%-д сурах бичгийг хэвлэж, нийлүүлнэ.

## ХҮРСЭН ҮР ДҮН (2019–2022)

- БШУ-ны сайдын 2023 оны А/587 дугаар тушаалаар батлагдсан жагсаалт, шаардлагын дагуу судлагдахуун бүрээр сургалтын хэрэглэгдэхүүний судалгаа хийж, шаардлагатай болон дутагдалтай хэрэглэгдэхүүний хэрэгцээг тодорхойлон хөрөнгө оруулалтыг төлөвлөх үндэс бүрдсэн. Мөн эдгээрийг сургалтын хэрэглэгдэхүүний техникийн тодорхойлолт боловсруулахад ашиглаж байна.
- ЕБС-ийн 1–12 дугаар ангийн сургалтын хэрэглэгдэхүүний жишиг жагсаалтыг боловсруулж, Боловсрол судлалын үндэсний хүрээлэнгийн захирлын 2022 оны А/70 дугаар тушаалаар баталсан.
- Казах хэл дээрх 22 сурах бичгийн агуулгын алдаатай холбоотой гомдол дахин гараагүй бөгөөд сурагчид, ялангуяа математикийн өгүүлбэртэй бодлогын агуулгыг илүү сайн ойлгох болсон. 2022–2023 онд багшийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр Баян-Өлгий аймгийн сурагчдын ном, сургалтын хэрэглэгдэхүүний ашиглалт 2023 онд өмнөх оноос 8.6 хувиар өсөж, нийт судлагдахуунаар сурагчдын гүйцэтгэлийн дундаж 2.1 хувиар нэмэгдсэн байна.
- 21 аймгийн 197 цэцэрлэгийн 5 настай хүүхдэд (бэлтгэл бүлэг) зориулсан 45 нэр төрлийн, 180 ширхэг сургалтын хэрэглэгдэхүүний багцыг 2023 оны 5 дугаар сард нийлүүлж, 16,071 хүүхэд (48 хувь нь эмэгтэй) үр шимийг хүртэж, хот, хөдөөгийн цэцэрлэгүүдийн хангалтын ялгааг бууруулахад эерэг нөлөө үзүүлсэн.
- 2022–2023 онд зохион байгуулсан багшийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр ЕБС-иуд сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүний ашиглалт 2023 онд 78.76 хувь болж, өмнөх оноос 7.76 хувиар өссөн байна.
- Түрээсийн хэлбэрээр ашиглах 2.7 сая ширхэг сурах бичгийг 7.4 тэрбум төгрөгөөр хэвлэн, төрийн өмчийн 649 сургуульд нийлүүлсэн. Нийт 161,373 (54.9 хувь нь эмэгтэй) сурагч сурах бичиг ашиглаж байв.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
БОЛОВСРОЛЫН ЯАМ

# ТӨСӨЛ 1-АХБ: ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙН ҮЕД БОЛОВСРОЛЫН ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ

ADB
ASIAN DEVELOPMENT BANK

## БҮРЭЛДЭХҮҮН 3: СУРГАЛТЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮНЭЭР ХАНГАХ




6-12 дугаар ангийн 2.7 сая ширхэг сурах бичгийг хэвлүүлэн төрийн өмчит бүх сургуульд түгээв.



ЕБС-ийн бага ангийн казах хэл дээрх 22 сурах бичгийн орчуулгыг сайжруулав.



Орон нутгийн 197 цэцэрлэгт 5 настай хүүхдэдзориулсан 45 нэр төрлийн 180 ширхэг сургалтын хэрэглэгдэхүүний багцыг нийлүүлэв.




Сурах бичгийн цаасны сорилын төхөөрөмж

# БҮРЭЛДЭХҮҮН 4: ЕБС-ИЙН БАГШ, УДИРДАХ АЖИЛТНЫ МЭДЛЭГ, ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛНЭ

## ХҮРЭХ ҮР ДҮН

- Боловсролын ерөнхий газрын цахим сургалтын **bagsh.edu.mn** платформыг хөгжүүлж, багш нарын үндсэн болон мэргэжил дээшлүүлэх сургалтуудыг онлайнаар зохион байгуулах боломжийг бүрдүүлсэн. Тус платформд ESIS болон MOES системийн бүртгэлийн эрхээр нэвтрэх нөхцөлийг ханган ашиглалтад оруулна.
- Үнэлгээ болон сурагч төвтэй, хүртээмжтэй заах арга зүйн чиглэлээр мэргэжил дээшлүүлэх онлайн хөтөлбөрийн 4 модулийг боловсруулж, **bagsh.edu.mn** платформд байршуулна.
- Удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалтын модулийг боловсруулж, сургагч багш нарыг бэлтгэн, удирдах ажилтнуудыг чадавхжуулах танхимын болон цахим сургалтыг зохион байгуулна.
- Мэргэжлийн хөгжлийн үндсэн сургалтыг танхим–цахим хосолсон хэлбэрийн хөтөлбөртэй болгон боловсруулж, **bagsh.edu.mn** платформд байршуулна.
- Насан туршийн боловсролын багш нарын мэргэжлийн хөгжил болон цахим ур чадварыг дээшлүүлэх зорилгоор 21 аймаг, 9 дүүргийн насан туршийн боловсролын төвийн 50 мэргэжилтнийг сургагч багшаар бэлтгэн, 4 бүсэд нийт 557 багшийг чадавхжуулсан.

## ХҮРСЭН ҮР ДҮН

- Тус платформд одоогийн байдлаар нийт 50,684 багш хамрагдсан байна. Үүнээс БХДҮТ-ийн 1 кредит цагийн ЕБС-ийн төрөлжсөн сургалтад 28,303 багш, СӨБ-ийн төрөлжсөн сургалтад 8,254 багш, нийслэлийн СӨБ болон ЕБС-ийн багш нарын мэргэжлийн хөгжлийг дэмжих 2 кредитийн төрөлжсөн сургалтад 23,326 багш тус тус хамрагдсан.
- Мөн платформд байршуулсан удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх модульт сургалтад ЕБ болон СӨБ-ын нийт 597 захирал (үүнээс 68 хувь нь эмэгтэй) ажлын байран дээрээсээ хамрагдаж, гэрчилгээ авсан.
- Байгалийн ухааны лабораторийн менежмент болон багаж, хэрэгслийн ашиглалтыг сайжруулах чиглэлээр байгалийн ухааны багш нарын 31.3 хувь буюу 1,097 багшийг (үүнээс 85 хувь нь эмэгтэй) сургалтад хамруулсан.

# БҮРЭЛДЭХҮҮН 4: ЕБС-ИЙН БАГШ, УДИРДАХ АЖИЛТНЫ МЭДЛЭГ, ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛНЭ



- Сурагч төвтэй идэвхтэй сургалтын арга зүй; хууль, эрх зүй; төсөв санхүүгийн шинэчлэлийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх сургалтын хөтөлбөр
- ЕБС-ийн удирдах ажилтан, БГ-ын мэргэжилтэнг чадавхжуулах сургалт.

- Сургагч багш - 66
- Удирдах ажилтан –1018

- Сургагч багш - 90
- Удирдах ажилтан - 1173

69% буюу 810 нь эмэгтэй

100%



- Насанд хүрэгчдэд зориулсан "МХХТ-ийн боловсролын жишиг хөтөлбөр",
- Насан туршийн суралцахуйн төвийн багшийг чадавхжуулах бүсийн сургалт

- Сургагч багш - 50
- НТСТ-ийн багш - 582

- Сургагч багш - 50
- НТСТ-ийн багш - 557

72% буюу 401 эмэгтэй

100%



- 47 сургуулийн нөхцөл байдлын судалгаа-10, 11 ангийн БУ 3 хичээлийн 78 туршилтын удирдамж,
- Математик, БУ-ны 12 хичээлийн хосолсон сургалтын цахим агуулга,
- Хосолсон сургалтын арга зүй турших удирдамж боловсруулав.

- Сургагч багш - 5
- Удирдах ажилтан, багш - 36

- Сургагч багш - 5
- Удирдах ажилтан, багш - 402

83% буюу 333 нь эмэгтэй

100%




- Bagsh.edu.mn цахим сургалтын платформын ашиглалт хэвийн болж,
- 6 сургалт /үндсэн сургалт, бусад/ -д ЕБС-ийн багш нарыг чадавхжуулав.
- CS05: БЕГ-ын цахим сургалтын bagsh.edu.mn платформыг сайжруулах зөвлөх үйлчилгээний хүрээнд “Багшийн хөгжлийн бүлэг, төвийн удирдлага” болон “Санхүү” модулиуд ашиглалтад оров.

- Хичээл - 350
- Идэвхтэй суралцагч–51349
- Агуулга – 6767+

100%

## БҮРЭЛДЭХҮҮН 5: БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ, УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛНЭ

### ХҮРЭХ ҮР ДҮН

- Төсвийн төслийг бэлтгэх үйл явцыг цахимжуулах ажлыг эхлүүлэх хүрээнд боловсролын салбарын нөхцөл байдлын шинжилгээ хийж, төсвийн саналууд аймаг, дүүрэг, нийслэл, улсын түвшинд, мөн ЕБС болон СӨБ гэсэн ангиллаар нэгтгэгдэж буй эсэхийг туршсан. Туршилтын явцад илэрсэн алдаанд үндэслэн сайжруулалт хийж, холбогдох сургалтыг зохион байгуулан, 17 төрлийн маягт, заавар, аргачлал боловсруулахад БЯ-д дэмжлэг үзүүлсэн.
- Газарзүйн мэдээллийн системд суурилсан сургууль, цэцэрлэгийн барилга барих, өргөтгөх, засварлах хөрөнгө оруулалтын мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх зориулалттай нэгдсэн мэдээллийн системийг (planning.edu.mn) хөгжүүлж, боловсролын салбарын төсвийг тооцоолоход ашиглаж байна.
- **bagsh.edu.mn**, ГМС-д суурилсан хөрөнгө оруулалтын нэгдсэн систем болон салбарын түвшний системүүдийн серверийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор шаардлагатай 2 серверийг худалдан авч, БМТТ-д хүлээлгэн өгсөн.

### ХҮРСЭН ҮР ДҮН

- Төсөл нь боловсролын салбарын төсвийн төслийг бэлтгэх үйл явцыг цахимжуулах, нэвтрүүлэх ажлыг эхлүүлэхэд бодит дэмжлэг үзүүлсэн бөгөөд төсвийн төслийг цахимаар нэгтгэн хүлээн авч байна. Үүний үр дүнд боловсролын салбарын төсөв бэлтгэхэд жилд зарцуулагддаг 1 тэрбум төгрөгийг хэмнэж, төсөв боловсруулах, хянах, эцэслэх үйл явцын үр ашиг нэмэгдэн, оролцогч хүний нөөцийн ажлын ачаалал буурсан.
- Төслийн дэмжлэгтэйгээр газарзүйн мэдээллийн систем (ГМС)-д суурилсан сургууль, цэцэрлэгийн барилга барих, өргөтгөх, засвар хийх хөрөнгө оруулалтын мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх зориулалттай хөрөнгө оруулалтын нэгдсэн мэдээллийн системийг (http://planning.edu.mn/) хөгжүүлж, боловсролын салбарын төсвийг тооцоолоход ашиглаж байна.
- Мөн уг системийн тооцооллын үр дүнд үндэслэн улсын болон нийслэлийн хөрөнгө оруулалтыг хуваарилахад ашиглаж байна.
- Системийн серверийн хүчин чадлыг нэмэгдүүлснээр оргил ачааллын үед системийн даац, тогтвортой ажиллагаа сайжирсан.

## БҮРЭЛДЭХҮҮН 5: БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ, УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛНЭ



Суралцагч - 948'504

Сургалтын байгууллага - 2'433





- Гэрээ байгуулсан огноо: 10/06/2025
- Бараа нийлүүлсэн огноо: 10/08/2025
- Гүйцэтгэл: 100%
- Захиалагч байгууллага: Боловсролын яам
- Гүйцэтгэгч байгууллага: Ай Ти Зон ХХК
- Ажлын талбай: Боловсролын мэдээллийн технологийн төв

# 2

# ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙН ҮЕД БОЛОВСРОЛЫН ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ +1 ДЭХ НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН

# ТӨСӨЛ 2-АХБ: ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙН ҮЕД БОЛОВСРОЛЫН ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ+1 ДЭХ НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ



## 2026 ОНД АШИГЛАЛТАД ОРУУЛАХ СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГҮҮД



Баянзүрх дүүрэг, 24-р хороо, 100 ортой шинэ цэцэрлэг



Сонгинохайрхан дүүрэг, 15-р хороо, “Ирээдүй” 1-р ахлах сургууль, 320 суудалтай өргөтгөл (давхарлах)




Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, 6-р сургууль 320 суудалтай өргөтгөл (давхарлах)




Баянзүрх дүүрэг, 16-р хороо, 82-р цэцэрлэг 150 суудалтай өргөтгөл



Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8 дугаар баг, 6 дугаар цэцэрлэгийн 240 ортой өргөтгөл



Баянгол дүүрэг, 18-р хороо, 88 дугаар цэцэрлэг, 150 ортой өргөтгөл

# ТӨСӨЛ 2-АХБ: ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙН ҮЕД БОЛОВСРОЛЫН ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ +1 ДЭХ НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ

## 2027-2028 ОНД БҮРЭН АШИГЛАЛТАД ОРУУЛАХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

| | | |
|---|---|---|
|  |  |  |
| Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 3-р баг, 150 ортой цэцэрлэгийн өргөтгөл | Хөвсгөл аймаг, Ханх сум 3-р баг 150 ортой цэцэрлэгийн барилга | СХД, 15-р хороо, Ирээдүй 3-р бага сургууль 320 суудалтай өргөтгөл (давхарлах) |

3

# MON-P11
# “ИНЖЕНЕР ТЕХНОЛОГИЙН ДЭЭД БОЛОВСРОЛ” ТӨСӨЛ

БОЛОВСРОЛЫН ЯАМ

# ТӨСӨЛ 3-ЖАЙКА:“ИНЖЕНЕР ТЕХНОЛОГИЙН ДЭЭД БОЛОВСРОЛ” ТӨСӨЛ

| Зорилт | Төлөвлөлт | Гүйцэтгэл | Үр дүн | Тулгамдаж буй асуудал |
|---|---|---|---|---|
| **АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ ЧАДВАРЛАГ ХҮНИЙ НӨӨЦИЙГ БЭЛТГЭХ;** | Коосэн-200 оюутан сургах; | Хамрагдсан-177 /88,5%/ | 168 инженер-104 байгууллагад ажиллаж байна. | Аудитын зөвлөмжийн дагуу хөтөлбөрөөс хасагдсан 8 оюутанд зарцуулсан санхүүжилтийг эргэн төлүүлэх; */Боловсролын зээлийн сан/* |
| | Бакалавр-320 оюутан сургах; | Хамрагдсан-292 /91,5%/ | 284 инженер-157 байгууллагад ажиллаж байна. | |
| **ИНЖЕНЕРИЙН ХӨТӨЛБӨРИЙН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ;** | ШУТИС-30 хөтөлбөр шинэчлэх; | Шинэчилсэн-37 /100%/ | • Япон стандартад нийцсэн хөтөлбөр-37<br>• Магадлан итгэмжлэгдсэн-4 хөтөлбөр | - |
| | Коосэн-80 ном орчуулах; | Орчуулсан-80 /100%/ | • Зохиогчийн эрхийн гэрээ-Япон Улсын 3 компани<br>• Орчуулыг гүйцэтгэл-100% */9 сард сургалтад ашиглана/* | Орчуулсан сурах бичгийн хэвлэлийн зардал; */Төрийн өмчийн Коосэн/* |
| | Коосэн-Стандарт Коосэн-Цөм хөтөлбөр | Гэрээ байгуулсан | • Стандарт, цөм хөтөлбөр гэрээ- Коосэн нийгэмлэг<br>• Орчуулгын ажлыг эхлүүлэх */ажлын хэсэг байгуулсан/* | - |
| **БАГШИЙН СУРГАЛТ, СУДАЛГААНЫ ХӨГЖИЛД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ;** | Магисрт-50 судлаач сургах; | Хамрагдсан-37 /74%/ | • Багшлах хүний нөөц 34 нэмэгдсэн.<br>• Хичээлийн агуулга шинэчлэл хийгдсэн. | • Тогтвор суурьшилтай ажлын байр;<br>• Хөтөлбөрөөс хасагдсан 4 оюутанд зарцуулсан санхүүжилтийг эргэн төлүүлэх; */Боловсролын зээлийн сан/* |
| | Доктор-110 багш сургах; | Хамрагдсан-104 /94,5%/ | • Багшлах хүний нөөц 73 нэмэгдсэн.<br>• Хичээлийн агуулга шинэчлэл хийгдсэн | |
| | Зэргийн бус-320 багш хамруулах; | Хамрагдсан-689 /100%+/ | • Судалгааны хүний нөөц 689 нэмэгдсэн.<br>• Гадаад хамтын ажиллагаа нэмэгдсэн.<br>• Судалгааны чадавхи, тоо хэмжээ өссөн. | - |
| | Зочин проф-325 багш хамруулах; | Хамрагдсан-522 /100%+/ | • Гадаад хамтын ажиллагаа нэмэгдсэн.<br>• Судалгааны чадавхи, тоо хэмжээ нэмэгдсэн. | - |
| | Хамтарсан судалгаа-20 багийн үйл ажиллагааг эхлүүлэх; | 25 баг /100%+/ ***/МУИС, ШУТИС, ХААИС/*** | • Өгүүлэл /IF/ 409<br>• Өгүүлэл /гадаад/ 646<br>• Өгүүлэл /дотоод/ 478<br>• Гадаад харилцаа-89<br>• Оюуны өмч 98<br>• Гараанаы компани 5 | • Олон нийтэд сурталчилан таниулах;<br>• Судалгаар эдийн засгийн эргэлтэд оруулах; */үйл ажиллагааны зардал/* |
| **СУРГАЛТ СУДАЛГААНЫ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ НИЙЛҮҮЛЭХ;** | 1,6 тэрбум иенийн худалдах авалт хийх; ***/МУИС, ШУТИС, ХААИС/*** | 2,6 тэрбум иен<br>99 лаборатори<br>4434 төхөөрөмж | • Шинэ лаборатори<br>• Шинэ судалгаа<br>• Дундын лаборатори<br>• Чанар, үр дүн<br>• Хүртээмж<br>• Хэмнэлт | • Засвар үйлчилгээ; */их сургуулиуд/*<br>• Лаборант, техникч */бүтэц, орон тоо/* |

# ТӨСӨЛ 3-ЖАЙКА:“ИНЖЕНЕР ТЕХНОЛОГИЙН ДЭЭД БОЛОВСРОЛ” ТӨСӨЛ


















